ҮАГазраас 2016 онд нийлүүлэх аудитын болон үйл ажиллгааны төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛААС 10.1 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ БЭЛТГЭСЭН БАЙНА.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2016 ОН

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Төв аймгийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан Аудитын менежер О.Амаржаргал Ахлах аудитор Ц.Базарсад Т.Майцэцэг Шинжээч Ц.Хишигжаргал 2016 оны 9 дугаар сарын 01-ны өдөр Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70273204 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	**Товчилсон үгсийн тайлбар ..... 3** **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй ..... 4** Асуудал 1 Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн зардлын зүйлийг хувиарлахдаа орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлаагүйгээс зарим зардлыг бодит байдлаас зөрүүтэй тооцсон байна **.... 5-8** Асуудал 2 Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг гарсан зардлаар нь тайлагнаагүйгээс зарим зардлын гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдсан байна.**..... 9-10** **Дүгнэлт ..... 11** **Зөвлөмж ..... 12** Холбогдох байгууллагын санал: **Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал ..... 13** **Саналд өгсөн тайлбар 13**

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
СТХ	Сонгуулийн тухай хууль
СТБ	Сонгуулийн төв байгууллага
САСТХ	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
ТАХ	Төрийн аудитын тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НББ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтан болон Улсын Их Хуралд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

1. УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх
2. Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх

Аудитад аймгийн Сонгуулийн хороо болон сумдын хэсгийн хороодын санхүүгийн баримт материал, цагийн бүртгэл, урамшуулал хоол унааны мөнгө олголт, батлагдсан төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл, бараа материалын тайлангууд, сонгуулийн хороо болон хэсгийн хороодын даргын захирамжууд зэрэг материалууд хамрагдсан болно.

Сумдын Сонгуулийн хороодын санхүүгийн баримт болон зарцуулалтын тайлангуудыг 2016 оны 7 сарын 18-нд, аймгийн Сонгуулийн хорооны зарцуулалтын тайлан болон санхүүгийн баримтуудыг 2016 оны 7 сарын 26-нд Аудитын байгууллагад ирүүлсэн болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

Төрийн аудитын тухай хууль
Төсвийн тухай хууль
Сонгуулийн тухай хууль
Сонгуулийн төв байгууллагын тухай
Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
СЕХ-ны 2016 оны 4-р тогтоол
Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль, тогтоомжууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, Ахлах аудитор Т.Майцэцэг, Ц.Базарсад, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ц.Хишигжаргал, А.Батлхагва нар 2016 оны 7-р сарын 20-ноос 8-р сарын 28-ны дүүсталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Асуудал 1	Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн зардлын зүйлийг хувиарлахдаа орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлаагүйгээс зарим зардлыг бодит байдлаас зөрүүтэй тооцсон байна.

УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн хорооны төсвийн зардлын зүйлийг хувиарлахдаа орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлаагүйгээс зарим зардлыг бодит байдлаас зөрүүтэй тооцсон байна.

Төв аймгийн сонгуулийн хороонд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу 429613.0 мянган төгрөг хуваарилагдсан байна. Үүнийг дараах байдлаар баталж ирүүлсэн байна. Үүнд:

- СЕХ-ны 2016 оны 4 сарын 27-ны өдрийн 142 тоот албан бичгийн 2-р хавсралтаар 85609.0 мянган төгрөг,
- 2016 оны 6 сарын 09-ны өдрийн 330 тоот албан бичгийн 2-р хавсралтаар 96149.0 мянган төгрөг,
- 2016 оны 6 сарын 22-ны өдрийн 392 тоот албан бичгийн 2-р хавсралтаар 247855.0 мянган төгрөг,

СЕХ-оос төсөв хуваарилсан тухай бүрд зардал тус бүрийг тооцоолсон аргачлал, зөвлөмжийг ирүүлсэн.

СЕХ-оос төсвийн санхүүжилтийг тухайн аймгийн газар нутгийн хэмжээ, сонгогчийн болон сум, хэсгийн тоо, тэдгээрт ажиллагсадын тоо зэргийг харгалзан тооцож олгосон ба зарим нэг зардлыг тооцохдоо бусад аймагтай адил жишгээр тооцсон нь дараах зардлууд илүү төсөвлөхөд нөлөөлсөн байна. Жишээ нь: сумаас аймгийн төв орох унааны зардлууд, аймгийн төвд хийх сургалтын автомашины /шатахуун/ зардлууд бодит байдлаас илүү тооцогдсон байна.

Төв аймгийн сонгуулийн хороо нь 27 сумдын хэсгийн хороодод 288110.8 мянган төгрөгийг, аймгийн сонгуулийн хороонд 141502.2 мянган төгрөгийг зарцуулахаар хуваарилсан байна. Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодын зардлыг хуваарилахдаа сумдын хүн амын тоонд үндэслэн тогтоосон хэсгийн хорооны тоо, ажиллагсадын тоонд болон СЕХ-ноос ирүүлсэн аргачлал зөвлөмжийн дагуу тооцогдсон.

Харин унааны зардал болон автомашины зардлуудыг бодит байдалд тулгуурлалгүй, СЕХ-ны жишгээр тооцож хуваарилсан нь бодит хэрэгцээ шаардлагаас илүү тооцогдсон байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн үйл ажиллагааны зардлаас 53866.1 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн хэдий ч зарим зардлуудыг арвилан хэмнэлттэй зарцуулах боломжтой байсан байна.

СЕХорооноос 3-н удаагийн санхүүжилтээр нийт 429613.0 мянган төгрөгийн батлагдсан төсвийг бүрэн авсан байна. Төв аймгийн сонгуулийн хорооны төрийн сан дахь 140022001 тоот дансаар 2016 оны 5 сарын 16-аас 2016 оны 7 сарын 25-ны хооронд 375746.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 53866.1 мянган төгрөгийг СЕХороонд буцаан төвлөрүүлсэн байна.

Батсүмбэр сум 234.4 мянган төгрөг, Баян сум 974.9 мянган төгрөг, Баянцогт сум 363.4 мянган төгрөг, Жаргалант сум 0.8 мянган төгрөг нийт 1573.5 мянган төгрөгийн төсвийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн бол бусад сумд батлагдсан төсвийн хэмжээнд тулгаж зарцуулсан байна.

СЕХ-ноос ирүүлсэн төсвийг өгөгдсөн зөвлөмжийн дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэхийг аймаг, сумдын сонгуулийн хороодоос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлан, материалын тайлангуудаас үзэж шалгав.

Сумдын салбар, хэсгийн хороо бүр холбогдох зардлуудаас уртасгагч, бичгийн тавиур, тооны машин, галын хор, флаш диск, тугны суурь, хяналтын камер гэх мэт дахин ашиглах боломжтой эд зүйлсийг худалдан авсан хэдий ч сонгуулийн үйл ажиллагааны дараа сумдын Засаг даргын тамгын газарт шилжүүлэн өгч данс бүртгэлд тусгуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төв аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хууль тогтоомж суртчилах зардлаас - нууцлалтай сейф 359.9 мянган төгрөг, төмөр шкаф 309.9 мянган төгрөг, ус буцалгагч 164.9 мянган төгрөг, баримт үдэгч 250.0 мянган төгрөг, суурин компьютер 2599.9 мянган төгрөг, зөөврийн компьютер 999.9 мянган төгрөг, принтер 369.9 мянган төгрөг, бусад төхөөрөмж 3 ширхэг 449.7 мянган төгрөг, сүлжээний төхөөрөмж 254.8 мянган төгрөг, цаас зүсэгч 85.0 мянган төгрөг нийт 5843.9 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн.
- Болзошгүй зардлаас - 1782.8 мянган төгрөгөөр аймгийн ЗДТГазрын 3 өрөөнд хөшиг, 1093.4 мянган төгрөгөөр камерийн систем суурилуулах зэрэгт зарцуулсан нь тухайн зардлыг “байгалийн гэнэтийн аюул, цаг агаарын нөхцөл байдлаас гол ус үерлэх, зам хаагдах, холбоо тасрах тохиолдолд онцгой байдлын зориулалтаар ашиглана” гэсэнтэй нийцээгүй байна. Мөн эдгээр нь СЕХорооны 2016 оны 03 сарын 02-ний өдрийн 04 тоот тогтоолын 3.2-т сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.
- Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардлаас - гадна гэрэл 150.0 мянган төгрөг, Форд 2.5 кв цахилгаан үүсгүүр 1199.9 мянган төгрөгөөр бэлтгэсэн.
- Аймгийн сонгуулийн хороо нь гишүүдэд хоолны мөнгийг төсөвлөсөн хэмжээгээр олгохоос гадна 2016.05.16-аас 2016.07.25-ны хооронд зоогийн газар, ресторануудад 12 удаагийн шилжүүлгээр нийт 4214.7 мянган төгрөгийг хоолны үнэнд шилжүүлсэн байна. Үүнээс Хархорум шинэ зуунд 950.0 мянган төгрөг, Солонго зоогийн газарт 1340.0 мянган төгрөг нийт 2290.0 мянган төгрөг нь сургалт семинарын хоолны зардал гэх боловч холбогдох шийдвэр, удирдамж болон анхан шатны баримтууд байхгүй байна. Мөн 1924.7 мянган төгрөг нь аймгийн сонгуулийн хорооны гишүүдийн хоолны үнэ ба анхан шатны баримтаас тулган шалгавал 2016.03.29-нд

аймгийн ИТХурал 150.8 мянган төгрөг, саналын хуудас устгах ажлын хэсгийн зардал 140.0 мянган төгрөг гэх мэтээр зарцуулсан байгаа нь тооцож олгосон урамшуулал болон хоолны мөнгөтэй давхардаж илүү зардал гаргасан байна.

- Шатахууны зардалд Монсуль ХХК-нд шатахууны үнэ нийт 9248.8 мянган төгрөг, Магнайтрэйд ХХК-д 8494.8 мянган төгрөгийн шатахууны талон, сумдын сонгуулийн хорооны ажиллагсдын нэрийн дансанд 3386.6 мянган төгрөгийн унааны зардал нийт 21130.2 мянган төгрөгийг шатахууны үнэнд шилжүүлж зарцуулсан. Шатахууны зарцуулалт, ажил гүйцэтгэсэн тухай жолоочийн замын хуудасны тооцоо бодолтыг шалгахад:
  - ✓ Монсуль ХХК-иас 7 сарын 7-10-ний өдрүүдэд сумдад батламж хүргэж өгөх ажилд сонгуулийн хорооны гишүүдэд 733.5 мянган төгрөгийн, иргэн Г.Гантөмөрт сонгуулийн хорооны гишүүдийн ажилласан хугацаатай давхардуулан 853.7 мянган төгрөгийг зарцуулсан нь төсвийг үрэлгэн зарцуулсан байна.
  - ✓ Аудитаар явсан ажил нь тодорхойгүй нотлогдохгүй баримтаар 4806.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсанаар тайлагнасаныг илрүүлсэн. Үүнд: Магнайтрейд ХХК-иас авсан шатахууны талонаас 05 сарын 05-ний өдөр сонгуулийн хорооны гишүүд сумдад ажиллахад зээл олгосон гэж 1521.7 мянган төгрөг, 06 сарын 03-ний өдөр цугларалт болоогүй байхад 27 сумын сонгуулийн хорооны дарга нарын нэрсийн жагсаалтыг гаргаж 2010.0 мянган төгрөг, 07 сарын 01-нд 17 сумын сонгуулийн хорооны нэрсээр 1274.3 мянган төгрөг, нийт 4806.0 мянган төгрөгийн талоныг зарцуулснаар баримт бүрдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, НББ-ийн тухай хуулийн 20.1.4-д хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- Аймгийн сонгуулийн хороо болон сумдын сонгуулийн хорооны машин техникийн хүрэлцээ хангалттай байхад иргэн Г.Гантөмөртэй өдрийн 120.0 мянган төгрөгөөр тооцож ажил гүйцэтгэх гэрээ хийж, 9 хоног ажиллуулан 1080.0 мянган төгрөгийг гэрээг дүгнэсэн баримтгүйгээр олгосон. Уг гэрээний ажил гүйцэтгэсэн болон замын хуудасны тооцоог шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:
  - ✓ Жолоочын замын хуудсанд захиалагч, болон хэрэглэгчийг иргэн Г.Гантөмөр өөрөө гарын үсэг зурсан
  - ✓ Иргэн Г.Гантөмөр нь Ланд крузор 200 маркын 41-46 УБЧ дугаартай автомашинаар 9 удаагийн шатахууны зөвшөөрлөөр сонгуулийн хорооны техник, хэрэгсэл хүргэх албан ажлаар гэж 527 л буюу 853.7 мянган төгрөгийн шатахууныг авсан байна. Тухайлбал: 6-р сарын 22-нд Жаргалант, Сүмбэр суманд 97 л, 6 сарын 23-нд Баянжаргалан суманд 62 л, 6 сарын 24-нд Баян-Өнжүүл суманд 60 л, 6 сарын 25-нд Бүрэн суманд 89 л, 6 сарын 26-нд Эрдэнэсант суманд 116 л, 6 сарын 27-нд Улаанбаатар хотод 26 л шатахууныг гэх мэт
  - ✓ Г.Гантөмөрийн суманд ажилласан хугацаа сонгуулийн хорооны гишүүдийн суманд ажилласан хугацаатай давхардсан. Жишээ нь Сонгуулийн хорооны дарга Нямдорж 6-р сарын 22-нд Жаргалант, Сүмбэр суманд 00-03 ТӨА дугаартай Прадо 150 маркын авто машинаар 96 л шатахуун авч ажилласан, МТБагийн гишүүн Б.Батхишиг 6 сарын 22-нд Жаргалант, Сүмбэр, Угтаал, Заамар, Цээл сумдад техник хэрэгсэл хүргэх ажлаар ТӨВ-19-54 дугаартай Уаз Пургон автомашинд 121 л шатахуун авч ажилласан байна

- Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт сумын сонгуулийн ажилтнуудад гэрчилгээ олгох сургалтыг 03 сарын 28, 29-ний өдрүүдэд зохион явуулсан ба хамрагдсан ажилтнуудын томилолтын зардлыг сумаас, унааны зардлыг баримтыг үндэслэн аймгийн сонгуулийн хороо байгуулагдсаны дараа олгохыг аймгийн ИТХТ-ийн 2016 оны 03 сарын 28-ний 68 тоот албан бичиг хүргүүлсэн. Гэтэл аймгийн сонгуулийн хорооноос 3666.0 мянган төгрөгийн албан томилолтын мөнгийг сургалтанд хамрагдсан иргэдэд олгож төсвийг үрэлгэн зарцуулсан байна.
- Аймгийн сонгуулийн хорооны холбооны зардлыг шалгаж үзэхэд тайланд хавсаргасан Мобикомийн төлбөрийн баримтаар хорооний гишүүн 16 хүний утасны төлбөрийн үлдэгдэл 15.0-68.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй гэж тооцогдсон байна. Энэ нь 2016 оны 6 сарын 27 өдөр шилжүүлсэн 650.0 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд зарцуулах шаардлагагүй байсныг нотолж байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтуудыг зөрчсөнөөс гадна Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дугаар тогтоолын 3.2 дах заалт болон СЕХорооноос ирүүлсэн төсвийн зардлыг зардлын зүйл анги хооронд шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар хэрэглэхгүй байх гэсэн зөвлөмжийг мөрдөж ажиллаагүй байна

Төв аймгийн Сонгуулийн хороо нь сонгуулийн үйл ажиллагааны зардлаас 53866.1 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн хэдий ч зарим зардлуудыг аривлан хэмнэлттэй зарцуулах боломжтой байсан байна.

Аудитын явцад сонгуулийн зардлаас бэлтгэсэн 10095.1 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ЗДТГазарт хүлээлгэн өгч, данс бүртгэлд тусгуулах зөвлөмжийг өгч хэрэгжилтийг ханган ажиллаа.

Эдгээрийг эс тооцвол аймгийн сонгуулийн хороо нь “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайланг гаргах тухай журам”-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулсан байна. Сумдын сонгуулийн хороодын харилцах болон материалын тайлангууд, аймгийн сонгуулийн хорооны харилцах дансны баримтуудыг холбогдох журмын дагуу, анхан шатны баримтуудад тавигдах шаардлагын дагуу бүрдүүлэн, хавсаргаж эмх цэгцтэйгээр үдсэн байна.

	УИХурлын болон аймаг, нийслэлийн ИТХурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл
Асуудал 2	Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг гарсан зардлаар нь тайлагнаагүйгээс зарим зардлын гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдсан байна.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг гарсан зардлаар нь тайлагнаагүйгээс зарим зардлын гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдсан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны төсвийг СЕХ-нд тооцоолон төсөвлөж, санхүүжилт хийх тухай бүрд нь зардлуудыг тооцох аргачилал зөвлөмжийг ирүүлж байжээ.

СЕХ-2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 3-р хавсралтын дагуу сумдын сонгуулийн хороод нь төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж, хянуулан аймгийн сонгуулийн хороонд нэгтгүүлсэн байна.

Аймаг, сумдын Сонгуулийн хорооны зардлын нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсөв 429613.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 375746.9 мянган төгрөгийг зарцуулж 53866.1 мянган төгрөг хэмнэгдсэнийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна. Хэмнэгдсэн нийт төсвийн 52292.6 мянган төгрөг нь аймгийн сонгуулийн хорооноос, 1573.5 мянган төгрөг нь сумдын сонгуулийн хорооноос тус тус хэмнэгдсэн байна.

Төв аймгийн Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан /мянган төгрөг/

№	Зардлын нэр	НИЙТ ДҮН		
		төсөв	гүйцэтгэл	хэтрэлт хэмнэлт
1	Саналын хуудас устгах зардал	1,000.0	1,000.0	-
2	Тогтоол проткол бусад маягт хэвлүүлэх зардал	250.0	86.5	(163.5)
3	Сургалтын зардал	47,809.0	15,091.7	(32,717.3)
4	Бичиг хэргийн зардал	23,501.6	23,501.6	-
5	Шуудан холбооны зардал	23,250.0	22,312.2	(937.8)
6	Унааны зардал	47,701.2	46,756.1	(945.1)
7	Хууль тогтоомж суртачилах зардал	8,000.0	7,343.9	(656.1)
8	Санал авах байр бэлтгэх зардал	17,200.0	17,200.0	-
9	Саналын хуудас хүргэх	7,171.0	-	(7,171.0)
10	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	13,128.0	7,740.0	(5,388.0)
11	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	600.0	545.2	(54.8)
12	Томилолтын зардал	6,045.0	4,773.0	(1,272.0)
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	4,214.0	1,350.0	(2,864.0)
14	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	190,992.8	189,654.5	(1,338.3)
15	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	31,353.2	31,118.8	(234.4)
16	Болзошгүй зардал	3,000.0	2,876.2	(123.8)
17	Бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч нарын урамшуулал, хоолны зардал	1,700.0	1,700.0	-
18	Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх	2,697.2	2,697.2	-
	Нийт дүн	429,613.0	375,746.9	(53,866.1)

Аймаг, сумдын Сонгуулийн хороод Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу хуваарилагдсан төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэхийг шалгахад:

- Төв аймгийн Сонгуулийн хорооны 2016 оны 6 сарын 6-ны өдрийн 73 тоот албан бичгээр, бичиг хэргийн зардалд 101.6 мянган төгрөг, төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх зардалд 2097.2 мянган төгрөг нийт 2198.8 мянган төгрөгийг хэмнэгдсэн унааны зардлаас бүлэг хооронд зохицуулалт хийлгэх хүсэлт гаргасан. СЕХ-ний ажлын албаны 2016 оны 07 сарын 01-ны өдрийн 206 дугаар албан бичгийн хавсралтаар зардлын зүйлд өөрчлөлт оруулж ирүүлсэн байна.

- Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх зардлаас 2016 оны 06 сарын 27-ний өдөр Акуа даймонд ХХК-д 2515.0 мянган төгрөгийг шилжүүлж, сонгуулийн суртчилгааны машины наалт 3000 ш-ийг 1500.0 мянган төгрөгөөр, штабын ажилтны үнэмлэх 1000 ш, ажиглагчын үнэмлэх 1000 ш, санал тэмдэглэх заавар 400 ш, ахлах зохион байгуулагчийн үнэмлэх 50 ш –ийг бүгд 1015.0 мянган төгрөгөөр худалдан авсан. Сонгуулийн өмнөх өдөр бичиг хэргийн ажилтан Ж.Баттогтох дээрх материалуудыг хүлээн авч, өөртөө шаардах хуудас бичиж зарлагдснаар тайлагнасан. Энэ нь харилцагч байгууллагаас хүлээн авсан болон материалыг тараасныг нотлох анхан шатны баримт байхгүй байна. НББ-ийн тухай хуулийн 3.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.6-д Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэж заасантай нийцэхгүй байна.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг гарсан зардлаар нь тайлагнаагүйгээс зарим зардлын гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдсан байна. Тухайлбал Сургалтын зардлыг үнэн зөв тооцож бүртгээгүйгээс аймгийн сонгуулийн хорооны зардлыг 32717.3 мянган төгрөгөөр хэмнэсэн. Унааны зардлаас хэтэрсэн 6094.0 мянган төгрөгийг ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардалд тайлагнасан байна.

Сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг зохих ёсоор хянаж хүлээн авсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4-д “Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажилласан тухай тайлан байхгүй байна.

Сумдын Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийн тайланг хэсгийн хороо тус бүрээр гаргуулж, мөнгөн хөрөнгийн болон, материалын тайланд холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэн, үдэж цэгцлэн аймгийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгсөн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн зардлын зүйлийг хувиарлахдаа орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлаагүйгээс зарим зардлыг бодит байдлаас зөрүүтэй тооцсон байна
2. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг гарсан зардлаар нь тайлагнаагүйгээс зарим зардлын гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдсан байна

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн:
ҮАГазраар уламжлан Сонгуулийн ерөнхий хорооны даргад зөвлөх нь

1. Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн зардлын зүйлийг хувиарлахдаа орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлан зардлыг бодитой үндэслэлтэй төлөвлөж байхыг анхаарч ажиллах

Төв аймгийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогчид зөвлөх нь:

1. СЕХорооноос ирүүлсэн зардлуудыг тооцох аргачилал зөвлөмжийг чанд мөрдөж ажиллах

Ахлах аудитор	Т.Майцэцэг
	Ц.Базарсад
Аудитор	Д.Пүрэвсүрэн
Шинжээч	Ц.Хишигжаргал
	А.Батлхагва

Холбогдох байгууллагын санал

ТӨВ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО
41100 Зуунмод, Төв аймаг
Утас: ..... Факс: .....

2016 07 29 № 68

танай ..... -ны № ..... -т

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Зөвлөмжийн биелэлтийн тухай

2016 оны Улсын Их Хурлын болон аймгийн ИТХ-ын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмжийн дагуу дараах тайлбаруудыг хүргүүлж байна.

-**Материалын тайлан:**

1.Тайлант хугацаанд 5 аж ахуйн нэгжээс 3,435,510 төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч нийт орлогын 41, зарлагын 30 ширхэг баримтаар зарцуулалтын тайланг гаргасан.

2.10,095,094 төгрөгийн 20 ширхэг эд хөрөнгө, техник хэрэгсэл худалдан авч орлогын баримт бүрдүүлэн бараа материалын тайлан гаргасан. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газар болон Байгаль орчин, аялал жуулчлалын газарт акт үйлдэн хүлээлгэн өгөв.

-**Шатахууны зарцуулалт**:

1.Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах хугацаанд Монсуль ХХК-наас 9,248,810 төгрөгийн шатахуун нэхэмжлэхийн дагуу авч зарцуулалтыг жагсаалт болон шатахуун олгох бичгээр олгон нийт орлогын 3, зарлагын 93 ширхэг /замын хуудас болон тооцооны хуудас/ баримтаар 9,248,810 төгрөгийн шатахуун зарцуулсан.

2.Гэрээгээр ажилласан Г.Гантөмөрийн гэрээ болон ажлын гүйцэтгэлийг харилцахын баримтанд, замын хуудас болон тооцооны хуудсыг шатахууны тайланд хавсарган үдсэн.

3.Тайлант хугацаанд Магнай трейд ХХК-наас 8,494,800 төгрөгийн шатахуун нэхэмжлэхийн дагуу талонаар авч зарцуулалтыг жагсаалтаар олгон нийт орлогын 2, зарлагын 113 ширхэг /замын хуудас болон тооцооны хуудас/ баримтаар 8,494,800 төгрөгийн шатахуун зарцуулсан.

ДАРГА Д.НЯМДОРЖ

My doc: A4 Toot-2016 /2/.